

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 67.080.10

Хушны самар. Техникийн шаардлага	MNS 5786:2007
Siberian Pine nut. Technical requirements	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2007 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2007 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэхүү стандартын шаардлагыг заавал мөрднө.

1. Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь Нарсны овог (*Pinaceae Lindl*)-т багтах Сибирийн хуш (*Pinus Sibirica /Rupr/ Mayr.*)-ны самрыг хүнсний зориулалтаар бэлтгэх, шалгаж хүлээн авах, савлах, хаяглах, хадгалах, тээвэрлэхэд хамаарна.

2. Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах баримт бичгийг иш татсан бөгөөд эдгээр стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны материалыас иш татаж хэрэглэнэ.

- CAC/RC P59:2005, Хушны самрын эрүүл ахуйн дүрэм

3. Ангилал

Хушны самрыг болц, хольц, өнгө, чийгийн байдлыг үндэслэн дараах 2 зэрэгт ангилна.

- Нэгдүгээр зэрэг
- Хоёрдугаар зэрэг

4. Техникийн шаардлага

- 4.1. Хушны самрыг түүж бэлтгэхдээ Байгаль орчны асуудал эрхэлсэн териин захиргааны төв байгууллага (БОЯ)-аас баталсан журмыг баримтална.
- 4.2. Түүхий эдийн зориулалтаар бэлтгэсэн хушны самар нь бүрэн гүйцэд боловсорсон идээтэй, боргоцойн хайрс, шилмүүс, модны холтос, өвснөөс сайн цэвэрлэгдсэн байна.

- 4.3. Хушны самар нь 1-р хүснэгтэд заасан мэдрэхүйн эрхтний үзүүлэлтийг хангана.

1-р хүснэгт – Мэдрэхүйн эрхтний үзүүлэлт

д/д	Үзүүлэлтийн нэр	Шинж чанар
1	Биет байдал	Самар нь шувтан гурвалжиндуу бөөрөнхий хэлбэртэй, гүйцэд боловсорсон идээтэй, гадуураа ясан бүрхүүлтэй давирхайгүй байна.
2	Өнгө	Хүрэн улаан, цайвар хүрэн
3	Үнэр	Хушны самрын идээний өвөрмөц үнэртэй. Гадны бусад үнэргүй байна.
4	Амт	Хушны самрын идээний өвөрмөц амттай. Гадны элдэв амтгүй байна.

- 4.4. Хушны самар нь 2-р хүснэгтэд заасан физикийн үзүүлэлтийг хангана.

2-р хүснэгт – Физикийн үзүүлэлт

д/д	Үзүүлэлтийн нэр	Шинж чанар	
		Нэгдүгээр зэрэг	Хоёрдугаар зэрэг
1	Самрын нийт чийглэг, %, ихгүй	12-16	16-20
2	Самрын болц	Бүрэн боловсорсон, жигд том хэмжээтэй (1000 ширхэг самрын жин 220 г-аас доошгүй)	Бүрэн бус боловсорсон, жигд бус, ихэвчлэн жижиг хэмжээтэй (1000 ширхэг самрын жин 180-220 г хүртэл)
3	Гадны хольц (хайрс, шилмүүс, холтос, өвс зэрэг), %-иас, ихгүй	2,0	6,0
4	Ясан бүрхүүл нь гэмтсэн, %-иас, ихгүй	Байж болохгүй	1,0
4	Дутуу болцтой самар, %-иас ихгүй	Байж болохгүй	2,0
ТАЙЛБАР: Бүрэн боловсорсон нь хатуу ястай, жигд цайвардуу хүрэн эсвэл хүрэн улаан өнгөтэй, давирхайгүй болсон байна.			

- 4.5. Хушны самар нь 3-р хүснэгтэд заасан нян судлалын үзүүлэлтийг хангасан байна.

3-р хүснэгт – Нян судлалын үзүүлэлт

д/д	Үзүүлэлтийн нэр	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ
1	Гэдэсний төрлийн эмгэгтөрөгч болон сальмонелл 25 г-д.	Илрэх ёсгүй
2	Хөгц 1 г-д, ихгүй	1×10^3
3	Шавьж түүний өндөг, авгалдайгаар бохирдсон байдал	Байж болохгүй

5. Дээж авах

Савласан бүтээгдэхүүнээс 4-р хүснэгтэд заасны дагуу шинжилгээнд дээж авна.

4-р хүснэгт

Тухайн савласан бүтээгдэхүүний жин, кг	Шинжилгээнд дээж авах хэмжээ, кг
10 хүртэл	0,5
11-20	1
21-ээс дээш	2

6. Шалгаж хүлээн авах

Хушны самрын чанарыг дараах стандартын дагуу шалгаж хүлээн авна.
Үүнд:

- MNS ISO 4891:1999, Хүнсний бүтээгдэхүүнд сальмонелл илрүүлэх ерөнхий арга;
- MNS 5169:2002, Хүнсний бүтээгдэхүүнээс үет хөлтөн, шавьж илрүүлэх арга;
- MNS 5132:2003, Хүнсний бүтээгдэхүүн. Мөөгөнцрийг таньж тодорхойлох арга;
- MNS 2431-77, Модлог ба бутлаг ургамлын үр. Үрийн чийг тодорхойлох арга.

7. Савлалт, хаяглалт

- 7.1. Хушны самрыг 50 кг хүртэл цэвэр жинтэйгээр агаар, чийг чөлөөтэй нэвтрэх шуудай, уутанд савлана.
- 7.2. Савласан бүтээгдэхүүний жингийн хэлбэлзэл нь $\pm 2,0\%$ -иас ихгүй байна.

7.3. Савны гадна талд буй шошго нь дараах мэдээллийг агуулсан байна.

- Бүтээгдэхүүний нэр
- Бэлтгэсэн байгууллагын нэр
- Зэрэг дугаар
- Жин
- Бэлтгэсэн он, сар, едөр
- Стандартын дугаар, тэмдэглэгээ

8. Хадгалалт, тээвэрлэлт

8.1. Хушны самрыг "Хүнсний барааны агуулах. Техникийн шаардлага MNS 5364:2004" стандартын шаардлага хангасан, 70%-иас ихгүй агаарын харьцангуй чийглэгтэй, 15°C-дээшгүй температуртай, агаар-жуулалттай байранд хадгална.

8.2. Савласан бүтээгдэхүүнийг шалнаас дээш 20-30 см өндөр тавиур дээр нарны гэрлийн шууд тусгалаас хол, хана, халаагуураас 1 м-ээс багагүй зайд хураана.

8.3. Энэ стандартын 8.1 ба 8.2-т заасан нөхцлийг хангасан агуулахад хушны самрыг 1 жил хүртэл хугацаагаар хадгална.

8.4. Битүүмжлэл сайтай, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан бүх төрлийн тээврийн хэрэгслэлээр тээвэрлэнэ.